



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТӨМӨГН ГАЗРЫН ЦЭРГИЙН ШТАБЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Хувь
1. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ							
1.1	Цэргийн штабын "Сургалтын нэгдсэн төлөвлөгөө"-г боловсруулан БХЯ-ны төрийн нарийн бичгийн даргаар батлуулах.	-	2023 оны төлөвлөгөөний биелэлт	Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний биелэлт үр дүн	Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний биелэлт	Цэргийн штабын "Сургалтын нэгдсэн төлөвлөгөө"-г батлан хамгаалах яамны холбогдох албан тушаалтнуудаар хянуулж Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан төлөвлөгөөнд заагдсан сургалтад холбогдох хүмүүсийг оролцуулж биелэлтийг ханган ажилласан.	100%
1.2	МУ-ын алсын хараа 2050 урт хугацааны хөтөлбөр, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Шинэ сэргэлтийн бодлогод Батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан арга хэмжээг орон нутагтаа хэрэгжүүлэх.	ОНТ	2023 оны төлөвлөгөөний биелэлт	Төлөвлөгөөний биелэлт үр дүн	Төлөвлөгөөний биелэлт	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэх, хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, "Оюутан-цэрэг" сургалтад суралцагчдын тоог нэмэгдүүлэх, цэргийн хугацаат болон гэрээт алба хаагчдын алба хаах хугацаанд амьдрах, ажиллах нөхцөлийг сайжруулах гэсэн 3 арга хэмжээг аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллагаа.	100%
1.3	Монгол улсын Засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг Говь-Алтай	ОНТ	2023 оны гэрээний биелэлт	Гэрээний биелэлт үр дүн	Гэрээний биелэлтийг хангах	Монгол Улсын Засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг Говь-Алтай аймагт төлөөлөн 2024 онд төлөөлөн	94.6%

	аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх.					хэрэгжүүлэх гэрээнд тусгагдсан 5 бүлэг, 32 нэр төрлийн ажил үйлчилгээг орон нутагт хэрэгжүүлэн ажиллалаа.	
1.4	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангах.	ОНТ	2023 оны төлөвлөгөөний биелэлт	Төлөвлөгөөний биелэлт үр дүн	Төлөвлөгөөний биелэлт	Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөнд 3 зорилт 5 арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг ханган ажиллалаа.	100%
1.5	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2024 онд хөгжүүлэх чиглэлд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан бодлогын зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангах.	ОНТ	2023 оны төлөвлөгөөний биелэлт	Төлөвлөгөөний биелэлт үр дүн	Төлөвлөгөөний биелэлт	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2024 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан бодлогын зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.	90%
1.6	Аймгийн ЗДТГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд цэргийн штабаас тусгасан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг хангах.	ОНТ	2023 оны төлөвлөгөөний биелэлт	Төлөвлөгөөний биелэлт үр дүн	Төлөвлөгөөний биелэлт	Аймгийн ЗДТГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд цэргийн штабаас 3 зорилт арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа.	100%
1.7	"Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын дээд зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө", "Орон нутгийн хамгаалалт", "Орон нутгийн цэргийг байгуулах бэлтгэлийг хангах төлөвлөгөө"-нүүдийг тодотгох орон нутгийн хамгаалалтын тогтолцоог нутаг дэвсгэртээ бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.	ОНТ	2023 онд хэрэгжүүлсэн арга хэмжээ	Төлөвлөгөөний биелэлт үр дүн	Тодотгол хийх, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө", "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-г тодотгон сумдын орон нутгийн отряд, сумангийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган томилгоот бүрэлдэхүүн, хүч хэрэгсэл, машин техникүүдийг тодотгон нөхөн хангалт хийж орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг зохион явууллаа.	100%
1.8	Батлан хамгаалахын хууль тогтоомж, Батлан хамгаалахын сайдын тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2024 оны байдлаар Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабт үйл ажиллагааны мэдээ тайланг хуваарийн дагуу нэгтгэн хүргүүлж ажиллалаа. Үүнд: Батлан хамгаалахын сайдын тушаал-4, Батлан хамгаалах яам, ТНБД-ын албан даалгавар-5, Зэвсэгт хүчний ерөнхий	100%

						хянан шалгагчийг тушаал-1, Зэвсэгт хүчний Ханжин штабын даргын тушаал-3, албан даалгавар-1, аймгийн Засаг даргын захирамж-8, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал-5, ирсэн бичиг цаасаар болон цахимаар-50, явсан-82 баримт бичгийг бүртгэн, хугацаатай албан бичгүүдийн хариуг цаг хугацаанд нь хэрэгжүүлэн мөнгөн төлбөрийн орлогын тайлан, акт, мэдээ зэрэг баримт бичгийг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.	
2. ЗАСАГ ДАРГА, ТАМГЫН ГАЗРЫН ДАРГАД ҮЗҮҮЛЭХ ЗАХИРГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭ							
2.1	МУ-ын Засгийн газар, Батлан хамгаалах салбар болон Засаг даргын үйл ажиллагаатай холбоотой арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалах салбарын талаар тусгагдсан зорилтуудаас орон нутагт хамааралтай заалтуудыг аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг Говь-Алтай аймагт 2024 онд төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, аймгийн ЗДТГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө, цэргийн штабын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг бодлогын бичиг баримтуудад батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр тусган хэрэгжүүлж ажиллалаа.	100%
2.2	Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагааг бүх нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, орон нутагт батлан хамгаалах бодлого, зорилт, зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймгийн иргэд, хөдөлмөрчид, цэргийн насны залуучуудад сурталчлах, Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 103 жилийн ой, Монгол цэргийн өдрийн хүрээнд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын эмэгтэй албан	100%

					хаагчдын дунд өөрдөстэй бүсгүйчүүд, марш-тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг, бүлэг, оны мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээн болон "Цол бүхэн сайхан" нэрэмжит тэмцээн, энгийн иргэдийн дунд "Засагт хан" буудлагын холбоотой хамтран буудлагын 3 төрөлт тэмцээн, сумын харцага цолтноос доош цолтой залуу бөхчүүдэд сумын заан цол олгох барилдаан зэрэг олон ажлыг зохион байгууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн санаачилгаар 2024 оныг "Ахлагчийн жил" болгон зарласантай холбогдуулан Алтай цэргийн хүрээний ахлагчийн жилийн нээлтийг хийж "Алтай" чуулгын уран бүтээлчидтэй хамтран "Эх орон" хүндэтгэлийн тоглолтыг зохион байгуулж Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймгийн иргэд, хөдөлмөрчид, цэргийн насны залуучуудад сурталчлан ажилласан. Монгол Улсад генерал цол олгож эхэлсний 80 жилийн ойн хүрээнд тус аймгаас төрөн гарсан генерал цолтнуудыг алдаршуулах, танилцуулах зорилгоор аймгийн 12 жилийн нэгдүгээр сургуулийн 6 бүлгийн 110 сурагч, 12 жилийн хоёрдугаар сургуулийн 5 бүлгийн 96 сурагч, сургуулийн нийгмийн ажилтан, 12 жилийн гуравдугаар сургуулийн 5 бүлгийн 83 сурагч, 12 жилийн Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн 5 бүлгийн 90 сурагч, нийт 370 гаруй сурагчдад "Эх оронч үзэл, үндэсний бахархал", "Улс орны хөгжилд хувь хүн бүрийн оролцоо" сэдвээр яриа танилцуулга хийж аймгийн Засаг даргын мөндчилгээг цахим хэлбэрээр
--	--	--	--	--	--

					генералуудад (1) бүрүүлэн ажилласан. Зэвсэгт хүчний Ханжин штабын даргын "Цэрэг татах, халах ажлыг зохион байгуулах тухай" 2024 оны мн/190, мн/204 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлага зохион явуулах тухай А/238, А/555 дугаар захирамжуудын дагуу цэрэг татлагыг зохион байгуулж явуулсан. Батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2024 оны А/159 дүгээр захирамжийн хүрээнд аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын "Дөл-2024" цогцолбор тэмцээнийг 2 үе шаттай зохион байгуулж явууллаа. Батлан хамгаалах яамны Ерөнхий хянан шалгагчийн 2024 оны тайлан, мэдээ ирүүлэх тухай 02/1359 дүгээр албан бичгийн хэрэгжилтийг хангаж дараах арга хэмжээг авч ажиллалаа. Тус арга хэмжээний хүрээнд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа харуул хамгаалалтын байгууллагуудын цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдэг хэрэглэж байгаа эсэх, зах болон худалдаа үйлчилгээний газрууд, оёдлын цех үйлдвэрүүдэд үйлдвэрлэх болон худалдан борлуулж байгаа байдал, цэргийн дүрэмт хувцасны хэрэглээний талаар хяналт, шалгалтыг аймгийн Цагдаагийн газартай хамтран зохион байгуулж ажиллалаа. Батлан хамгаалах сайдын 01, 02 албан даалгаврууд болон тухайн албан даалгавруудыг үндэслэн гарсан Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаал, мөн даргын 1^а -ийн 395 тоот албан
--	--	--	--	--	---

2.3	Засгийн газрын тогтоолыг үндэслэн цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдийг сургах, алба хаалгах ажлыг зохион байгуулах	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	40 хүн	Сургалтын үр дүн, биелэлт	даалгавруудын дагуу төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажилласан. Цэргийн дүйцүүлэх албыг 2024 онд биеэр хааж иргэдийг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Цэргийн албыг дүйцүүлэн хааж журам"-ыг тус тус үндэслэн сумдаас цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж хүсэлт гаргасан иргэдийн материалыг хүлээн авч, аймгийн Засаг даргын 2024 оны А/367 дугаар захирамжийн дагуу цэргийн дүйцүүлэх албанд 40 иргэнийг элсүүлж, "Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл" сургалтын хөтөлбөрийн дагуу 2024 оны 05 дугаар сарын 27-ний өдрөөс 06 дугаар сарын 09-ний өдрийг дуустал 14 хоногийн хугацаанд Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийг түшиглэн сургалтыг зохион байгуулж явууллаа.	100%
2.4	Сумдын ЗДТТ-ын дарга, багийн Засаг дарга нартай цэргийн бүртгэлийн сургалт, семинарыг зохион байгуулах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Монгол Улсын дайчилгааны тухай хууль, Цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу сумдын багийн Засаг дарга нарын "Цэргийн бэлтгэл" сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 20-22-ний өдрүүдэд зохион байгууллаа. Батлан хамгаалахын сайдын 2020 оны "Цэргийн сургалт бэлтгэлийн хөтөлбөр батлах тухай" А/121 дүгээр тушаалаар батлагдсан "Багийн Засаг дарга нар"-ын сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан нийт 24 цагийн сургалт бэлтгэлийг зохион байгуулж "Төрийн болон албаны нууцыг хамгаалах журам", "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам"-ыг бие бүрэлдэхүүнд танилцуулан нууц хадгалалт хамгаалалтыг чанд мөрдөх.	100%

					урьдчилан зааварчилгаа танилцуулан ажилласан.	Цэргийлэх талаар	
2.5	Зэвсэгт хүчний 103 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Зэвсэгт хүчний 103 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх	Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 103 жилийн ойн, Монгол цэргийн өдрийн хүрээнд тус аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас 17 төрлийн арга хэмжээг төлөвлөн төлөвлөгөөг боловсруулж аймгийн ЗДТГ-ын даргаар батлуулан биелэлтийг хангаж 03 дугаар сарын 14-ний өдрөөс 17-ний өдрүүдэд зохион байгууллаа. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулах Марш-тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг, бүлэг, оны мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээний нээлтийн арга хэмжээнд аймгийн Засаг дарга Г.Чинбат, аймгийн ЗДТГ-ын дарга Ш.Эрдэнэбат болон, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлага, алба хаагчид ЗДТГ-ын хэлтсийн дарга нар оролцлоо. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын эмэгтэй албан хаагчдын дунд мөрдөстэй бүсгүйчүүд арга хэмжээнд 80 гаруй албан хаагчид оролцож "Ажлын байран дахь сэтгэлзүй" сэдвийн хүрээнд онолын бага хурал хийгдсэн. Алтай цэргийн хүрээний аварга шалгаруулах марш-тактик тусгай бэлтгэлийн тэмцээнд эрэгтэй 8 тасаг, эмэгтэй 5 бүлэг, оны мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээнд 11 офицер, ахлагч оролцлоо. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд "Цол бүхэн сайхан" нэрэмжит даргс, ширээний теннис, буудлагын тэмцээн, энгийн иргэдийн дунд "Засагт хан" буудлагын	100%

					холбоотой хайр, ан том калибр, дурантай бага калибр, ил хараа гэсэн 3 төрлөөр явуулж аваргуудыг шалгарууллаа. Сумын харцага цолтноос доош цолтой залуу бөхчүүдийг барилдааныг Есөнбулаг сумын ЗДТГ, аймгийн биеийн тамир спортын газартай хамтран зохион байгуулсан. Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн болон Мэргэжлийн боловсролын сургуулийн сурагчдын дунд "Галын бэлтгэлийн норматив", "Магазин сумалгаа"-ны тэмцээнийг зохион байгууллаа. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч У.Хүрэлсүхийн санаачилгаар 2024 оныг "Ахлагчийн жил" болгон зарласантай холбогдуулан Алтай цэргийн хүрээний ахлагчийн жилийн нээлтийг зохион байгуулж Алтай чуулгын уран бүтээлчидтэй хамтран "Эх орон" тоглолтыг зохион явууллаа.
				Халхын голын ялалтын 85 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах, сурталчлах.	Ойг тэмдэглэн өнгөрүүлэх
					Засгийн газрын 2023 оны 487 тогтоолоор "Халх голын байлдааны ялалтын 85 жилийн ой"-г 2024 оны 08 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэх тогтоолын хүрээнд Батлан хамгаалах сайдын 2024 оны А/78 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу орон нутагт 2024 оны 06 дугаар сараас 08 дугаар сарын хооронд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган төлөвлөгөө боловсруулан ахмад дайчдын гавьяа зүтгэлийг алдаршуулах, дурсгалыг мөнхжүүлэх ажлуудын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдтай "Бид мартахгүй" уулзалт дурсамж ярилцлагыг ахмад дайчин Я.Алтангэрэл,

						Г.Амгалан нар  хамтран зохион байгуулж, "Эх түүхийн жим" сэдвийн хүрээнд АХА тэмцээнүүдийг тус тус зохион байгуулж уулзалт ярилцлага, тэмцээнд оролцсон хүүхдүүдтэй хамтран орон нутагт бүтээн байгуулж байгаа "Ид шидийн орон"-ы бүтээн байгуулалтын ажилд туслан "Халх голын байлдааны ялалт"-ын түүхэн буланг байгуулахаар болсон.	
2.6	Цэргийн бүртгэл явуулах, хяналт тавих.	ОНТ	Хэрэгжилтийн үр дүн	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Цэргийн бүртгэлийг 2023 оны 12 дугаар сарын 10-ний өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 20-ний өдрүүдэд зохион явуулсан. Цэргийн бүртгэлээр бэлтгэл офицер, бэлтгэл үүрэгтэн, авто техникийг бүрэн хамруулж цэргийн бүртгэлийн мэдээг батлагдсан маягтын дагуу зөв гаргах, хүн орхигдуулах, давхардуулах, зэрэг зөрчил гаргахгүй байхад анхаарч бүртгэлд хамрагддаггүй иргэдийн судалгааг гаргах, шинээр 18 нас хүрсэн иргэдийн бүртгэлийг хөтлөх, цэргийн үүрэгтний үнэмлэхийг олгох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, цэргийн үүрэгтний үнэмлэх гээгдүүлсэн иргэдэд үнэмлэх нөхөн олгох зэрэг арга хэмжээг авч ажиллалаа. Цэргийн бүртгэл явагдах хугацаанд сумдын удирдлага, багийн Засаг дарга нарт мэргэжил арга зүйн зөвлөмжийг утсаар өгч, зарим сумдад ажиллаж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн цэргийн бүртгэлийн үйл ажиллагааны явц, бэлтгэл үүрэгтний цэргийн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллав.	100%
	Цэрэг халах, татах ажлыг зохион байгуулах,	ОНТ	Хэрэгжилтийн үр дүн	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Зэвсэгт хүчний Үхэнжин штабын даргын "Цэрэг татах, халах ажлыг зохион байгуулах тухай" 2024 оны мн/190,	

2.7	Зэвсэгт хүчний ангийн үйл дэмжлэг ажиглагаанд үзүүлэх.	Улсын төсөв	Хэрэгжилтийн үр дүн	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	мн/204 дүгээр (10)аал, аймгийн Засаг даргын 2024 оны нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлага зохион явуулах тухай А/238, А/555 дугаар захирамжуудыг тус тус удирдлага болгон 2024 оны нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг тус аймгийн 18 сумыг хамруулан зохион байгуулж явуулсан. Ангид шинээр байгуулах барилга угсралтын ажлуудыг үе шаттайгаар гүйцэтгэх, орон нутгийн бүтээн байгуулалтад оролцуулах зэрэг ажлуудыг үе шаттайгаар эхлүүлээд байна. 2024 онд Зэвсэгт хүчний 341 дүгээр анги нь орон нутагт 340 метр урттай 3 эгнээ хатуу хучилттай авто замын ажлыг 193,248,416.00 төгрөгийн төсөвт өртгөөр гүйцэтгэсэн. Тухайн ажлыг 50 цэргийн албан хаагч, 15 техникээр хуучин авто замыг хуулж цэвэрлэх, далангийн чиг сэргээх, явган хүний зам, авто замын тэмдэг тэмдэглээ, авто замын гэрэлтүүлгийн ажлыг батлагдсан зураг, техникийн шаардлагын дагуу гүйцэтгэсэн.	100%
2.8	Зэвсэгт хүчний 341 дүгээр ангид орон нутагт бүртгэлтэй ажилгүй мэргэжил бүхий иргэдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх.	-	Хэрэгжилтийн үр дүн	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Зэвсэгт хүчний 341 дүгээр ангид шаардлагатай мэргэжлийн зарыг мэдээллийн хэрэгслээр тавьж, орон нутагт бүртгэлтэй ажилгүй ангид чухал шаардлагатай мэргэжлийн эмч, нягтлан бодогч, барилгын инженер, лабораторийн эрхлэгч зэрэг 14, бүтээн байгуулалтын ажилд түр хугацаагаар 30 гаруй иргэдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэн ажилласан.	100%
2.9	Аймгийн Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаал, шийдвэрийн биелэлт гаргах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Аймгийн Засаг даргын захирамж, Тамгын газрын даргын тушаал, шийдвэрийн биелэлтийг сар, улирал бүрээр гаргаж Засаг даргын бодлого, шийдвэрийн хэрэгжилт хариуцсан	100%

						мэргэжилтэнд (40) тухай бүр хүргүүлж ажиллалаа.	
2.10	Аймаг, сумдын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний дэдлага, сургалтыг зохион байгуулах.	ОНТ	Бүрэлдэхүүний тоо	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Аймгийн 11 сумын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүн, сумдын Тамгын газрын дарга нартай онц байдлын үед орон нутгийн хамгаалалтын үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, гүйцэтгэх үүрэгт нь чиглэсэн онолын мэдлэг, дэдлага, ур чадвар олгох, томилгоот нэгжийн гар нийлэмжтэй ажиллагааг хангах, үүрэг гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор "Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэл" сэдвээр "Хээрийн дэдлага сургалт"-ыг 2024 оны 09 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд Төгрөг суманд зохион байгуулан явууллаа. Тус сургалтад сумдын удирдлага, зохион байгуулах ажлын хэсэг, Цэргийн штаб, Зэвсэгт хүчний Жанжин штабаас томилгогдсон сургалтын хөдөлгөөнт бүлэг, Зэвсэгт хүчний 341 дүгээр анги, Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын сургагч багш нар болон, Алтай, Баян-Уул, Бугат, Дарив, Дэлгэр, Тайшир, Тонхил, Цээл, Халиун, Хөхморьт, Шарга сумдын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний нийт 53 хүний сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд 3 үе шаттайгаар зохион байгуулсан. Сургалтад нийт 22,684,585.00. төгрөгийг төсөвлөн зарцуулсан.	100%
2.11	Аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд аймгийн Засаг даргын	3.000.0 мян/төг	Тоо: 3 үе шаттайгаар	2023 оны үр дүн	Захирамж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.	Цэрэг-спортын "Дөл-2024" цолболбор тэмцээний I үеийг сумдад 2024 оны 03 дугаар сарын 18-нд зохион байгуулж сумдаас шалгарсан тасгуудыг аймгийн	100%

нэрэмжит "Дөл" цогцолбор тэмцээнийг зохион байгуулах.	Цэрэг-спортын				Засаг даргын нэгдүгээртэй хамт шалгаруулах II шатанд оролцуулж тэмцээнийг 2024 оны 04 дүгээр сарын 21-22-ний өдрүүдэд зохион байгуулж явууллаа. Тэмцээний тэргүүн байранд ерөнхий боловсролын II сургуулийн Э.Мөнхдэлгэр захирагчтай тасаг шалгарч шилжин явах цом, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, дэд байранд Тонхил сумын ерөнхий боловсролын сургуулийн Г.Баасанжаргал захирагчтай тасаг шалгарч мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар, гуттаар байранд ерөнхий боловсролын IV сургуулийн С.Тэмүүлэн захирагчтай тасаг шалгарч хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнагдлаа.	100%
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын алба хаагчдын ажиллаж, амьдрах нөхцөлийг сайжруулах, эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах;		-	Бүрэлдэхүүний тоо	Орон нутагт хэрэгжсэн эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулсан.	Захирамж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.	
2.12					Цэргийн штабын алба хаагчдын ажиллах нөхцөл боломжийг хангаж алба хаагчдын ажлын байранд засвар үйлчилгээ хийж 2 алба хаагчийн компьютер бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан. Орон нутагт хэрэгжиж байгаа эрүүл мэндийн дэд хөтөлбөрүүд болон аймгийн эрүүл мэндийн газраас зохион байгуулж байгаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, аймгийн ЗДТГ-ын дотооддоо зохион байгуулсан алба хаагчдын эрүүл мэндийн үзлэгүүдэд бүрэн хамруулсан.	100%

2.13	“Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг томилогот нэгжийн сургалтыг зохион байгуулах.	5.000.0 мян/төг	Сумдад орон нутгийн хамгаалалтын томилогот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг бүсчилэн зохион байгуулсан байна.	2023 оны үр дүн	Захирамж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.	Аймгийн 11 орон нутгийн хамгаалалтын томилогот нэгжийн удирдах бүрэлдэхүүн, сумдын Тамгын газрын дарга нартай онц байдлын үед орон нутгийн хамгаалалтын үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, гүйцэтгэх үүрэгт нь чиглэсэн онолын мэдлэг, дадлага, ур чадвар олгох, томилогот нэгжийн гар нийлэмжтэй ажиллагааг хангах, үүрэг гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “Орон нутгийн хамгаалалтын томилогот нэгжийн удирдах бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэлт” сэдвээр “Дадлага сургалт”-ыг 2024 оны 09 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд Төгрөг суманд зохион байгуулан явуулаа. Тус сургалтад сумдын удирдлага, зохион байгуулах ажлын хэсэг, Цэргийн штаб, Зэвсэгт хүчний Жанжин штабаас томилогдсон сургалтын хөдөлгөөнт бүлэг, Зэвсэгт хүчний 341 дүгээр анги, Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын сургагч багш нар болон, Алтай, Баян-Уул, Бугат, Дарив, Дэлгэр, Тайшир, Тонхил, Цээл, Халиун, Хөхморьт, Шарга сумдын орон нутгийн хамгаалалтын томилогот нэгжийн удирдах бүрэлдэхүүний нийт 53 хүний сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд 3 үе шаттайгаар зохион байгуулсан. Сургалтад нийт 22,684,585.00. төгрөгийг төсөвлөн зарцуулсан.	100%
2.14	“Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах.	2.000.0 мян/төг	Хамруулах бүрэлдэхүүний тоо	2023 оны үр дүн	Захирамж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.	Батлан хамгаалах сайдын 2024 оны А/35 дугаар тушаалын дагуу “Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын журмын дагуу сонгон шалгаруулалтад тэнцсэн 8 оюутанд цэргийн тусгай мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу “Цэргийн	100%

					ерөнхий бэлтгэл, Цэргийн сургалтыг 2024 оны 04 дүгээр сарын 06-наас 2024 оны 06 дугаар сарын 02-нийг хүртэл хугацаанд Бямба, Ням гарагуудад сургалтыг тус тус орон нутагт зохион байгуулж Цэргийн мэргэжлийн бэлтгэл сургалтыг Зэвсэгт хүчний 123 дугаар ангид зохион явуулж тус сургалтад 7 оюутан хамрагдсан.				Хил хамгаалахад туслах хүчний үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ болон үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хамтарч ажиллахад хилийн цэргийн 0214 дүгээр ангийн соёлын төвийн, техник хэрэгсэл, сандал шинэчлэхэд зориулж 50 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлсэн.	100%
3. ИРГЭДЭД ҮЗҮҮЛЭХ ЗАХИРГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭ										
2.15	Хил хамгаалахад туслах хүчний үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ болон үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хамтарч ажиллах.	-	Хамруулах бүрэлдэхүүний тоо	2023 оны үр дүн	Захирамж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.					
3.1	Төрийн батлан хамгаалах үйлчилгээтэй холбоотой иргэний өргөдөл, санал, гомдлыг хуулийн хугацаанд барагдуулах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр				Иргэд болон цэргийн жинхэнэ алба хааж байгаа байлдагч нарын ар гэрээс гаргасан гачигдлын шалтгаанаар цэргийн албанаас чөлөөлөх, орон нутгийн түр чөлөө хүссэн, бусад өргөдөл, гомдлыг хүлээн авч бүртгэн зохих шатны байгууллагад уламжлах, шийдвэрлэх хариуг иргэдэд амаар болон утсаар уламжлан шийдвэрлэж ажилласан.	100%
3.2	Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж, цэргийн насны болон өсвөр насны иргэдийн дунд цэрэг-эх оронч хүмүүжил олгоход чиглэсэн 3-аас доошгүй арга хэмжээг зохион байгуулах;	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр				Хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч хүмүүжил олгох, эх орон, эх хэл, түүх, соёл, уламжлал, ёс заншлаараа бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил суулгаж, эх орноо батлан хамгаалах залгамж халааг бэлтгэх зорилгоор тус аймгаас энхийг сахиулах ажиллагаанд оролцсон төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын офицер, ахлагч нар	100%

					ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад үүрэг гүйцэтгэсэн газар орон болон ёс заншил, энхийг сахиулах ажиллагаа, батлан хамгаалах бодлого, зэвсэгт хүчний чиг хандлагын талаар яриа таниулга хийлээ. Есөнбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн болон Мэргэжлийн боловсролын сургуулийн сурагчдын дунд Монгол цэргийн өдрийн хүрээнд "Галын бэлтгэлийн норматив", "Магазин сумалгаа"-ны тэмцээнийг зохион байгууллаа. Засгийн газрын 2023 оны 487 тогтоолоор "Халх голын байлдааны ялалтын 85 жилийн ойн" хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдтай "Бид мартахгүй" уулзалт ярилцлагыг ахмад дайчин Я.Алтангэрэл, Г.Амгалан нартай хамтран дурсамж уулзалт ярилцлага, "Эх түүхийн жимээр" сэдвийн хүрээнд АХА тэмцээнүүдийг тус тус зохион байгууллаа. Монгол Улсын Залуучуудын өдрийг тохиолдуулан үндэсний сургагч багш бэлтгэх сургалт, соёлын эвент болон залуучуудын оролцоонд тулгуурласан нийгэмд тустай үйл ажиллагааг орон даяар шат дараатайгаар зохион байгуулах зорилготой "Эх оронч залуу" арга хэмжээг "Соёлын бүтээлч сарын аян"-ы хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээнд Зочин илтгэгчээр аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дайчилгааны офицер хошууч Г.Мөнхбаяр, уригдан илтгэл тавьлаа. Энэ үеэр:
--	--	--	--	--	---

							-“Эх орон-Үндэс” бахархал” сэдэвт сургалт, -“Байгууллагын соёл” сэдэвт сургалт, -“Харилцаа хандлага” сэдэвт сургалт, -Үндэсний бичгийн 30 бүтээлийн үзэсгэлэн, -Байгалийн түүхт болон үзэсгэлэнт газруудын 15 шилдэг зургийн үзэсгэлэн, -Монголчуудын өв соёл, бурхан шашин, гэрэл зургийн түүх, музейн шилдэг үзмэрийн дээжис 45 номын үзэсгэлэн, -Байгалийн түүхт болон үзэсгэлэнт газрын видео контентуудыг үзүүлсэн.					
3.3	Цэргийн насны залуусыг эрүүлжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж, үр дүнг тооцох.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр		Эрүүл мэндийн газартай хамтран “Иргэнийг цэргийн албанд эрүүл мэндээр тэнцүүлэх журмын дагуу эрүүл мэндийн шалтгаанаар тэнцээгүй 18-26 насны эрчүүдийг эрүүлжүүлэх” төлөвлөгөөг боловсруулан ажиллаж 2023 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар эрүүл мэндээр тэнцээгүй 104 иргэн буюу 59.7%-ийг эмчилгээнд хамруулан эрүүлжүүлсний үр дүнд 2024 оны нэгдүгээр ээлжээр 26 иргэний эрүүл мэнд сайжирч цэргийн албанд татагдаж байсан бол 2024 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаар эрүүл мэндийн шалтгаанаар мөн 104 иргэн чөлөөлөгдөж эрүүл мэндээр хасагдсан бөгөөд 88 буюу 84.6%-ийг эмчилгээнд хамруулан эрүүлжүүлж, 15 буюу 14.4% байнгын хяналтад байх иргэн, 1 иргэнийг лавлагаа шатлалд илгээсэн байна. Тухайн цэрэг татлагуудаар эрүүл мэндээр хасагдсан иргэдийг 100% эрүүл мэндийн байгууллагын хяналт, эмчилгээнд хамруулсан.	100%				
3.4	Хугацаат цэргийн алба хааж буй дайчдын цэргийн албаны үйл ажиллагаатай танилцах,	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр		Зэвсэгт хүчний 256, 339 дүгээр ангиудад алба хааж байгаа цэргийн албан хаагчдын цэргийн албаны үйл	100%				

	тэдний ар гэрт нь дэмжлэг тусалцаа үзүүлэх					ажиллагаа, сургалт, бэлтгэлтэй танилцах арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 08, 09-ний өдрүүдэд цэргийн штабаас зохион байгуулж аймаг орон нутагт хэрэгжиж байгаа бүтээн байгуулалт бусад үйл ажиллагааны талаар яриа таниулга хийж орон нутгийн удирдлагуудын мэндчилгээг дамжуулж аймгийн Засаг даргын гарын бэлгийг тус ангиудад алба хааж байгаа дайчдад гардуулсан.	
3.5	Цэргийн албанаас халагдсан иргэдийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх ажлыг хэвшил болгох.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2023 оны хоёрдугаар ээлжээр Зэвсэгт хүчний 256, 339 дүгээр ангиудад цэргийн албаа хаагаад халагдсан дайчидтай орон нутгийн ажил олгогч байгууллага болон Зэвсэгт хүчний 341 дүгээр анги, аймгийн цагдаагийн газар, дотоодын цэрэг, "Хан-Алтай" ресурс, Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас сул чөлөөтэй байгаа ажлын байруудын талаар яриа таниулга хийлээ. Тус арга хэмжээний хүрээнд "Хан-Алтай" ресурс уул уурхайн компанийн ажлын байранд 5 иргэн бүртгүүлж, Зэвсэгт хүчний 341 дүгээр анги болон аймгийн цагдаагийн газар, дотоодын цэрэг, онцгой байдлын газруудад орж ажиллах хүсэл сонирхолтой байгаагаа уламжилсан дайчдын баримт бичгийг бүрдүүлэн тухайн байгууллагуудад уламжилсан.	100%
3.6	Цэргийн албанд татагдсан иргэдийн ар гэр, цэргийн жинхэнэ албанаас халагдсан иргэдэд нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Зэвсэгт хүчин болон Хилийн цэргийн ангиудад хугацаат цэргийн албанд татагдаж цэргийн алба хааж байгаа амьжиргааны түвшин доогуур орлоготой 14 сумын 50 малчин өрхөөс цэрэгт үр хүүхэд нь алба хааж байгаа 20 байлдагчийн ар гэрийнхэнд Улаан загалмай, Дэлхийн зөн, Японы хүүхдийн ивээх сан зэргүүдтэй хамтарч малын	100%

						тэжээл, хоол (хүнс), эд материалын дэмжлэг үзүүлсэн.	
3.7	Их, дээд сургууль, Ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн боловсролын сургуулийн оюутан, сурагчдад энхийг сахиулагчдын өдрийн хүрээнд "Монгол цэрэг" сэдэвт Дэлхийн цэрэг" сэдэвт сурталт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчид болон мэргэжлийн сурталт үйлдвэрлэлийн төв, АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар АШУУИС-ийн оюутнуудад батлан хамгаалах бодлого, зорилт, Зөвсөгт хүчний үйл ажиллагаа, энхийг дэмжих ажиллагааны зорилго, ач холбогдол, Монгол Улсын энхийг сахиулагчдын үйл ажиллагааг сурталчлах, тэдэнд эх оронч үзэл төлөвшүүлэх зорилгоор 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр "Монгол цэрэг-Дэлхийн цэрэг" сэдэвт сурталт сурталчилгааны ажлыг зохион байгууллаа. Энэхүү сургалтад аймаг дахь Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас энхийг дэмжих ажиллагаанд оролцсон алба хаагчдыг оролцуулан үүрэг гүйцэтгэсэн ажиллагааны онцлог, цагийн байдал, тухайн газар орны ард иргэдийн зан заншил, ахуй амьдралын талаар богино хэмжээний видео бичлэгүүдийг үзүүлж яриа, танилцуулга хийсэн. Тус сургалтад нийт 563 оюутан, сурагч хамрагдлаа.	100%
4. БАТЛАН ХАМГААЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ТӨРИЙН БОЛОН ХУВИЙН ХЭВШЛИЙН АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ЗОХИОН БАЙГУУЛНА							
4.1	2024 оны цэргийн бүртгэлийн явц сум, багийн бүртгэлийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн үйл ажиллагааг шалган туслах ажлыг зохион байгуулж, заавар зөвлөмжөөр хангаж ажиллах.	1.200.0 мян/төг	2021 оны тоо бүртгэл	2023 оны үр дүн, биелэлт	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Цэргийн бүртгэлийн ажлыг иргэдэд сурталчлах, иргэдийн хамрагдалтыг сайжруулах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мөн иргэд олноор цуглардаг зах, худалдаа, үйлчилгээний төвүүдэд сурталчилгааны зурагт самбар байршуулан иргэдэд мэдээлэл өгч, хувийн болон төрийн байгууллага, аж	90%

							ахуйн нэгжүүдийн удирдлагын шуурхай хурал дээр алба хаагчдаа бүртгэлд хамруулах тухай чиглэл өгч, бэлтгэл үүрэгтний судалгаа гаргуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Аймгийн Засаг даргын сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулах, сургалтын хөтөлбөрийн хүрээнд "Цэргийн бүртгэлийг сум, багт зохион байгуулах" сэдэвт сургалтыг "Цэргийн албаны тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 34 дүгээр зүйлд заасан хуулийн заалтууд болон "Цэргийн бүртгэл явуулах журам" -ын талаар цахимаар зохион байгуулсан. Мөн ЗДТГ-аас зохион байгуулсан сум, багийн Засаг дарга нарийн сургалтаар сум, багт цэргийн бүртгэлийг хэрхэн зохион байгуулах, анхан шатны нэгжид нэрийн бүртгэлийг хөтлөх аргачлалыг өгч ажилласан.	
4.2	Цугларах бүрэлдэхүүний дадлагыг зохион тодотгох.	байрын сургалт явуулж	500.0 мян/төг	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн, биелэлт	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Цугларах, Шилжүүлэх байрын удирдлага, ирц бүртгэх хэсэг, анги, команд зохион байгуулах хэсэг, аж ахуйн тасгийн томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй сургалтыг явуулж, хөтлөгдөх баримт бичгүүдийг боловсруулан, хөтөлбөрийг цэргийн штабын даргаар батлуулан сургалтыг зохион байгуулж явууллаа.	100%
4.3	Шилжүүлэх бүрэлдэхүүний дадлагыг зохион тодотгох.	байрын сургалт явуулж	100.0 мян/төг	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн, биелэлт	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг зарцуулах журмын дагуу хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаар хүрсэн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн нэрсийг гарган мөнгөн төлбөр төлөх мэдэгдэх хуудас хүргүүлж ажилласан бөгөөд Төрийн сан	100%
4.4			-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	140 сая төгрөг	Үйл ажиллагааны хэрэгжилтээр		

						банканд 162 (100) төгрөгийн мөнгөн төлбөрийн орлогыг төвлөрүүлээд байна.	
4.5	Аймаг, сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын 18-50 насны цэргийн бэлтгэл үүрэгтэн, бэлтгэл офицеруудын цэргийн үүргийн биелэлтийн үзлэг, хяналт шалгалт хийх.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	22 аж ахуй нэгж	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Батлан хамгаалах тухай, Төрийн албаны тухай, Дайчилгааны тухай, Цэргийн албаны тухай, Төрийн хяналт, шалгалтын тухай хуулиуд, аймаг, нийслэлийн Цэргийн штабын дүрэм, Цэргийн штабын даргын баталсан хуваарийн дагуу батлан хамгаалах хууль тогтоомжийн хяналт шалгалтыг аймаг, сумдын төсөвт байгууллага, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагад зохион байгуулж ажиллалаа.	100%

5. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД

5.1	БХЯ, ЗХЖШ-аас зохион байгуулахаар төлөвлөгдсөн сургалтуудад хамрагдах.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	3 сургалт	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалт, орон нутгийн хамгаалалтын бэлтгэл сургалтын офицеруудын сургалт 2024 оны 09 дүгээр сарын 22-27-ны өдрүүдэд зохион байгуулагдаж сургалтад цэргийн штабын албан тушаалтнууд оролцсон. Мөн Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдах бүрэлдэхүүний цугларалт, 2024 оны 11 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан орон нутаг дахь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөнүүдэд цэргийн штабын дарга оролцсон	100%
5.2	Орон нутагт явагдах цэргийн сургалтын төлөвлөлтийг боловсруулж, хугацаанд нь	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2024 оны сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрээнд	100%

	сургалтыг явуулах, холбогдох хүмүүсийг татан оролцуулах.				төлөвлөгдсөн сургалтуудыг хуулийн хугацаанд зохион явуулж холбогдох албан тушаалтан, иргэдийг хамруулсан.	
5.3	Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдтэй хийх сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	40	40	100%
5.4	Цэргийн штабын бие бүрэлдэхүүн офицеруудыг ажлын байран дээрээ суралцах, ур чадвараа дээшлүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж үр дүнг эрхэмлэх.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100%
5.5	Цэргийн штабын офицеруудын сургалтыг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/94 дүгээр тушаалаар батлагдсан	-	Сургалтын хөтөлбөрийн хүрээнд	3	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	100%

	“Даргын бэлтгэл” сургалтын хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах.					талаар сургалт зохион байгуулж ажилласан. Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/94 дүгээр тушаалаар батлагдсан “Даргын бэлтгэл” сургалтын хөтөлбөрийн дагуу удирдахуйн ухаан, цэргийн сургалт бэлтгэл, албан хэрэг хөтлөлт ба нууцын горим, цэргийн штабын үйл ажиллагаа сэдвийн хүрээнд нийт 48 цагийн хичээл сургалтыг цэргийн штабын офицеруудад аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Хууль эрх зүйн хэлтэс, Архивын тасаг, Тагнуулын ерөнхий газрын Говь-Алтай аймаг дахь хэлтэстэй тус тус хамтран зохион байгууллаа.	
5.6	Аймгийн цэрэг татлагын товчоо болон сумдын цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнтэй цэрэг татлагын сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2024 оны цэрэг татлагыг зохион байгуулах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон бүрэлдэхүүн, сум, багийн Засаг дарга нартай цэрэг татлагын өргөтгөсөн хуралдааныг зохион байгуулж цэргийн насны залуучууд болон идэрчүүдийн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулах, цэргийн насны иргэдийн суурь өвчлөл, өнөөгийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ цэрэг татлагын ажлыг зохион байгуулах болон Батлан хамгаалах яам, ЗХЖШ-аас өгсөн үүрэг, чиглэлийг танилцуулж ажиллалаа.	100%
5.7	Сум, багийн Засаг дарга, нарын сургалтыг зохион байгуулах, төсөв хөрөнгийг шийдвэрлэх.	500.0 мян/төг	Сургалтын хөтөлбөрийн хүрээнд	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дугаар хэсгийг үндэслэн сумдын Засаг дарга нарын цэргийн бэлтгэл сургалтыг аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа, удирдлагын хэлтэстэй хамтран 2024 оны 02 дугаар сарын 12-14-ний хооронд цахим хэлбэрээр зохион байгуулсан.	100%

						Цэргийн штабын (1) сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу багийн Засаг дарга нарын нэгдүгээр шатны "Цэргийн бэлтгэл" сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 20-22 өдрийн хооронд зохион байгууллаа. Сургалтаар нийт 24 цагийн цэргийн бэлтгэл сургалтыг лекц, хэлэлцүүлэг, ярилцлага хэлбэрээр зохион байгуулсан	
6. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ							
6.1	Нутаг дэвсгэртээ батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сурталчлах.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт батлан хамгаалах салбарын талаар тусгагдсан зорилтуудаас орон нутагт хамааралтай заалтуудыг аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөө, аймгийн ЗДТГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөө, цэргийн штабын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө зэрэг бодлогын бичиг баримтуудад батлан хамгаалах бодлого, хууль тогтоомж үйл ажиллагааг тусган сурталчлан хэрэгжүүлж ажиллалаа.	100%
6.2	Цэргийн албаны тухай хуулийн дагуу ээлжит цэрэг татлагын ажлыг зохион байгуулах.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын "Цэрэг татах, халах ажлыг зохион байгуулах тухай" 2024 оны мн/190, мн/204 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлага зохион явуулах тухай А/238, А/555 дугаар захирамжуудыг тус тус удирдлага болгон 2024 оны ээлжит цэрэг татлагын ажлыг зохион байгууллаа.	100%
6.3	Орон нутгийн хамгаалалт болон даагавар дайчилгааны биелүүлэх чадамжийг дээшлүүлэх.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Дайчилгааны бэлэн байдлыг хангах, дайчилгааны даагавар биелүүлэх чадамжийг дээшлүүлэх талаар арга хэмжээ авч 20 тонны чингэлэг, 4х4, 4х8 хэмжээтэй өвөл, зуны майхан, potebok, зөөврийн ширээ, сандал, хээрийн эвхдэг ор, зэвсэглэл хадгалах галд тэсвэртэй	100%

						зориулалтын тусгай сейф, дохиоллын систем, цахилгаан үүсгүүр, каск, хамгаалах хантааз, өнгийн хантааз, уртасгагч цахилгааны залуур, зуух, яндан зэрэг материал хэрэгслийг худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.	
6.4	Засгийн газрын тогтоолыг үндэслэн цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдэд төлбөрийн хэмжээг тогтоон, төлүүлж, аймгийн төрийн сангийн дансанд төвлөрүүлэх.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг зарцуулах журмын дагуу хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаар хүрсэн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн нэрсийг гарган мөнгөн төлбөр төлөх мэдэгдэх хуудас хүргүүлж ажилласан бөгөөд Төрийн сан банканд 162 сая төгрөгийн мөнгөн төлбөрийн орлогыг төвлөрүүлээд байна.	100%
6.5	Улсын дайчилгааны шинэчлэн боловсруулах, тодотгоход мэргэжлийн дэмжлэг үзүүлэх.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2019 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Улсын дайчилгааны даалгаврыг шинэчлэн боловсруулахад мэргэжлийн дэмжлэг үзүүлж ажиллалаа.	50%
6.6	Дайчилгааны даалгаврын дагуу Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 304 дүгээр тусгай салбартай тогтоосон хугацаанд тодотгол хийх.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	1 ангийн 1 команд	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 304 дүгээр тусгай салбарын дугаар командад хүн, техникийг оногдуулан бүртгэж тодотголыг цаг хугацаанд нь хийж ажиллалаа.	100%
6.7	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг даалгаваржуулах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	"Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө", "Орон нутгийн цэргийн бэлтгэлийг хангах, байгуулах төлөвлөгөө"-ний дагуу иргэдийг оногдуулан бүртгэж, байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн гар дээр байгаа галт зэвсэг, машин техникуудийг даалгаваржуулсан.	100%
6.8	Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн цэргийн	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Аймгийн цэрэг-стратегийн үнэлгээг нийгэм, эдийн засгийн статистик үзүүлэлтэд үндэслэн цэргийн ажиллагаанд үзүүлэх нөлөөг "Цэргийн	100%

	ажиллагаанд үзүүлэх нөлөөг тооцон дүгнэлт гаргах.					штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө", "Орон нутгийн цэргийн бэлтгэлийг хангах, байгуулах төлөвлөгөөнүүдэд тусган ажилласан.	
6.9	Улсын дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэх, мэдээлэл боловсруулахад хамтран ажиллах.	ОНТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Улсын дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд аймгийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, цэргийн дайчилгааны үеийн удирдлага, дайчилгааны бэлэн байдлын түвшин, дайчилгааны бэлтгэл нөөцийн байдал, цэргийн дайчилгаа явуулах боломж, техникийн судалгаа, төлөвлөгөө батлуулахад шаардагдах лавлах өгөгдхүүнүүдийг бэлэн болголоо.	100%
6.10	Албан байгууллагаас ирсэн төрийн болон цэргийн нууц баримт бичигт бүртгэл хяналтын карт хөтөлж, хугацаанд нь шийдвэрлэх.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Цэргийн штабын маш нууц, нууц баримт бичиг, ном материалын 2024 оны хагас жил, жилийн эцсийн тооллогыг явуулж өгүүлбэр актыг 3 хувь үйлдэн хувийг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабт тус тус хүргүүлсэн. Сумдад ашиглагдан хадгалагдаж байгаа нууц баримт бичгийн хадгалалт хамгаалалт болон батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа байдалд шалган туслах ажлыг явуулж ажилласан.	100%
6.11	Тус хэлтэст хадгалагдаж байгаа төрийн болон албаны нууц материалуудад хагас жил болон жилийн эцсийн нууцын тооллогыг хугацаанд нь зохион явуулах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ЗХХЦШ-ын даргын 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/163 дугаар тушаалын дагуу ЗХХЦШ-ын Мэдээллийн аюулгүй байдлын хэлтсээс төрийн болон албаны нууцын горимын хэрэгжилт, мэдээллийн аюулгүй байдал, архив бичиг хэрэгт шалган туслах ажлыг 2023 оны 05 дугаар 23-24-ний өдрүүдэд явуулсан. Цэргийн штабын дайчилгааны бэлэн байдлын онц чухал-маш нууц, маш нууц, нууц баримт бичиг, ном материалын	100%

						тооллогыг зохион байгуулж өгүүлбэр актыг 3 хувь үйлдэн нэгдүгээр хувийг Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газарт, хоёрдугаар хувийг Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого стратегийн төлөвлөлтийн газарт тус тус хүргүүлсэн.	
6.12	Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж буй сар улиралын хуваарьт ажлуудыг чанартай зохион байгуулах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 оны үр дүн	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Аймгийн ЗДТГ-аас зохион явуулсан цаг үеийн арга хэмжээ, хурал зөвлөгөөнүүдэд тогтмол оролцож Бурхан буудай уулын тахилга, Галын тахилга, мод тарих зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажилд цэргийн штабын бие бүрэлдэхүүн оролцсон.	100%
6.13	Хугацаат мэдээ тайланг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабт хүргүүлэх.	-	2023 оны төлөвлөгөөний биелэлт	Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний биелэлт үр дүн	Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний биелэлт	Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабт үйл ажиллагааны мэдээ тайланг хуваарийн дагуу нэгтгэн хүргүүлж ажиллалаа.	100%

Төсвийн шууд захирагч

/Ш.Эрдэнэбат/

Төлөвлөгөөг үнэлсэн:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Нэгжийн дарга

/Д.Төмөрбаатар/

Тайлагнасан:

Цэргийн штабын дарга, хурандаа